



Улаанбаатар хот

2017 оны 03 дүгээр сарын 13

**БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ
БАЙГУУЛЛАГУУДАД ҮЗҮҮЛЭХ ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

Нэг.Зорилго

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын материалын үйлдвэрлэл явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд Монгол Улсын "Төрийн хяналт шалгалтын тухай", "Байгаль орчныг хамгаалах тухай", "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай", "Газрын тухай", "Усны тухай", "Хог хаягдлын тухай", Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилт, стандартын мөрдөлтийг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч эрсдлийг бууруулах арга хэмжээ авахад оршино.

Хоёр. Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх бүрэлдэхүүн

Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтсийн Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Б.Энхбат, Байгаль орчны хяналтын улсын байцаагч Ө.Мөнхбаяр, Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч М.Ууганбаяр, Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Л.Болдбаяр, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Ч.Хуваах, Барилга техникийн хяналтын улсын байцаагч Д.Алтантуяа нартай хамтран хийж гүйцэтгэнэ.

Гурав.Хамрагдах аж ахуйн нэгж

Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэж буй 18 аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг хавсралт 1-д хавсаргав.

Дөрөв. Хийж гүйцэтгэх ажил

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 онд шинэчлэн батлагдсан 2.23 дугаартай "Үйлдвэр, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас"-ыг ашиглан аж ахуйн нэгжүүдийн үнэлгээг тодорхойлно.

Хамрагдсан аж ахуйн нэгжүүдэд эрсдэлийг бууруулах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дотоод хяналтыг зохион байгуулах талаар зөвөлгөө өгнө.

Тав. Эхлэх болон дуусах хугацаа

Зөвлөн туслах үйлчилгээг 2017 оны 04 дугаар сарын 03-ний өдрөөс 05 дугаар сарын 15-ныг дуустал хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Үр дүн

1. Зөвлөн туслах үйлчилгээний үр дүнг нэгтгэн, хамрагдсан байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтанд танилцуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч, зөвлөмж хүргүүлэн ажиллана.

2. Хяналтын хуудасны нэгдсэн үнэлгээг шилэн хяналтын нэгдсэн санд оруулна.

ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА



Д.БАТ-ӨЛЗИЙ

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Б.ЭНХБАТ

ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АЖ АХУЙН НЭГЖҮҮД

Д/Д	Аж ахуйн нэгжийн нэр	Хугацаа	Улсын байцаагчийн /ахлах/ нэр
1	Авзага мээрэн ХХК	2017.04.03-2017.04.04	Б.Энхбат
2	Тунамал хийц ХХК	2017.04.06-2017.04.07	Б.Энхбат
3	Просолид стандарт ХХК	2017.04.10-2017.04.12	Б.Энхбат
4	Эйч энд эйч ремикон ХХК	2017.04.05-2017.04.06	Б.Энхбат
5	Өлзийконкрет ХХК	2017.05.01-2017.05.02	Б.Энхбат
6	Хүннүконкрет ХХК	2017.05.02-2017.05.03	Б.Энхбат
7	Мастер зуурмаг ХХК	2017.05.03-2017.05.04	Б.Энхбат
8	Эс си си ди трейд ХХК	2017.04.11-2017.04.12	Б.Энхбат
9	Авзага мээрэн ХХК	2017.04.13-2017.04.14	Б.Энхбат
10	Төгс зуурмаг ХХК	2017.04.17-2017.04.18	Б.Энхбат
11	Очирням ХХК	2017.04.18-2017.04.19	Б.Энхбат
12	Нью прогресс ХХК	2017.04.20-2017.04.21	Б.Энхбат
13	Батгүен ХХК	2017.05.08-2017.05.09	Б.Энхбат Д.Алтантуяа
14	Гангар-Инвест ХХК	2017.05.09-2017.05.10	Б.Энхбат Л.Болдбаяр
15	Премиумконкрет ХХК	2017.05.10-2017.05.11	Б.Энхбат М.Ууганбаяр Ч.Хуваах
16	Ноён сайхан ХХК	2017.05.01-2017.05.02	Ө.Мөнхбаяр
17	Эко төгс хийц ХХК	2017.05.03-2017.05.04	Ө.Мөнхбаяр
18	Өнгөт төмөр ХХК	2017.05.08-2017.05.09	Ө.Мөнхбаяр